

2. Ил хөдлөх эд хөрөнгийг өвлөх эд ил хөдлөх эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН хууль тогтоомжоор зохицуулагдана.

Гэрээслэл

Дөчин тавдугаар зүйл

1. Гэрээслэл уйлдэх, хучингуй болгох, туунчлэн зориг санаагаа буруу илэрхийлсний улмаас гэрээслэлийн талаар гарсан маргаантай асуудлыг өв залгамжлуулагч зориг санаагаа илэрхчлэх уедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН хуулиар зохицуулагдана.

2. Гэрээслэлийг уйлдэх, хучингуй болгох хэлбэрийг өв залгамжлуулагч, гэрээслэлийг уйлдэх, хучингуй болгох уедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН хуулиар зохиноулна. Гэрээслэлийг уйлдэх, хучингуй болгох хэлбэрийг тогтоохдоо нутаг дэвсгэрт нь гэрээслэл уйлдсэн буюу хучингуй болгосон Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН хуулийг дагаж мөрдсөн бол туунийг хучин төгөлдөр гэж узнэ.

Өв залгамжлах хэргийг авч хэлэлнэх эрх хэмжээ

Дөчин зургадугаар зүйл

1. Хэрэв энэхуу Гэрээгээр өөр зкурам тогтоогдоогуй бол хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг өв залгамжлуулагчийн нас барах уедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН байгууллага авч хэлэлнэх эрхтэй.

2. Ил хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН байгууллага авч хэлэлнэх эрхтэй.

3. Өвлөх эрхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ энэ зүйлийн I, 2 дахь ангийн заалтыг хэрэглэнэ.